

Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 10 тоот Хавсралт 1

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНКНЫ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Банк болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Банк нь сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийхдээ Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Журмыг дагаж мөрдөнө.
- 1.3. Журамд дурдагдсан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэг, 89 дугаар зүйлийн 89.2 дахь хэсэгт заасан этгээдүүдийг;
 - 1.3.2. “Эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнэ” гэж тухайн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн (Банкны хувьцаа болон үнэт цаасыг оролцуулан) үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, түүнийг худалдах үүрэг хүлээгээгүй худалдагч болон эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, худалдан авах үүрэг хүлээгээгүй худалдан авагч хоёрын харилцан тохиролцсон үнийг;
 - 1.3.3. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл болон Банкны дүрэмд эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон этгээдүүдийг;
- 1.4. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг шударга, зах зээлийн үнээр, бичгээр хийх бөгөөд эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэрийн дагуу хэлцэл хийх зөвшөөрлийг урьдчилан авсан байх зарчмыг баримтална.
- 1.5. Журмаар шууд зохицуулаагүй харилцааг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Банкны дүрэм, заавар, журмаар зохицуулна.

ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

- 2.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл: Банкны энгийн хувьцааны 20 хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, Банкны эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай доор дурдсан харилцаанд орсон бол Банктай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно. Үүнд:
 - 2.1.1. хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
 - 2.1.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
 - 2.1.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
 - 2.1.4. хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

- 2.2. Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүн, үйлчилгээг Банкны холбогдох заавар, журмын дагуу Банк нэгдмэл сонирхолтой этгээдэд үзүүлэх тохиолдолд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулах зөвшөөрлийг Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс Банкны Гүйцэтгэх удирдлагад тодорхой нөхцөлийн хүрээнд олгож болно.
- 2.3. Холбогдох хууль болон Журамд заасны дагуу ТУЗ-өөс зөвшөөрөл олгогдсон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг Гүйцэтгэх удирдлага, түүнээс эрх олгогдсон бусад этгээд нь Банкны холбогдох заавар, журмын дагуу байгуулж ажиллана.
- 2.4. Банк нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3 дахь хэсэгт заасны дагуу дараах хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж үзэхгүй. Үүнд:
- 2.4.1. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх;
- 2.4.2. Банк нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн худалдан авах;
- 2.4.3. Банк нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу худалдан авах;

ГУРАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ

- 3.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь дараах мэдээллийг ТУЗ-ийн дэргэдэх Ажлын албаар дамжуулан ТУЗ-д, эсхүл Дотоод аудитын газарт мэдээлэл хүргүүлнэ. Үүнд:
- /Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 05 тоот тогтоолоор тус хэсэгт өөрчлөлт оруулав./*
- 3.1.1. дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;
- 3.1.2. өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;
- 3.1.3. Банкны хийхээр төлөвлөж байгаа хэлцэлд сонирхлын зөрчил бүхий этгээд болох тухай;
- 3.1.4. Журмын 2.1 дэх хэсэгт заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар.
- 3.2. Журмын 3.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээллийг хүлээн авсан Дотоод аудитын газар эсхүл ТУЗ-ийн дэргэдэх Ажлын албаар дамжуулан ТУЗ нь аливаа гэрээ, хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох эсэхийг хянана.
- /Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөн найруулав./*
- 3.3. Банкны байгуулах гэж буй аливаа гэрээ, хэлцэл нь Журмын 2.2 болон 2.4 дэх хэсэгт зааснаас бусад сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тохиолдолд гэрээ байгуулах ажлыг хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий этгээд нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл авахаар ТУЗ-д хандана.
- /Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 05 тоот тогтоолоор тус хэсэгт өөрчлөлт оруулав./*
- 3.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргах бөгөөд шийдвэр гаргахад ТУЗ-ийн хараат бус гишүүд заавал оролцож, саналаа өгнө.

- 3.5. Дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл (хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл) хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар гаргана. Үүнд:
- 3.5.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Банкны ТУЗ-өөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 3.5.2. Банкны гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь Банкны урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 3.5.3. ТУЗ-ийн бүх хараат бус гишүүн нь хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх.
- 3.6. Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ тогтооно.

ДӨРӨВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

- 4.1. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно. Үүнд:
- 4.1.1. Хэлцэл хийхийн өмнөх сарын эцсийн тэнцлийн активын нийт дүнгийн 25 (хорин тав)-хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл;
- 4.1.2. Банкны өмнө гаргасан энгийн хувьцааны 25 (хорин тав) хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, түүнд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.
- 4.2. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 4.3. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

ТАВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ

- 5.1. Гүйцэтгэх удирдлага нь Журмын 4.1 дэх хэсэгт заасан мэдээллийг ТУЗ-ийн дэргэдэх Ажлын албаар дамжуулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэхээр хүргүүлнэ.
- 5.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн бүх гишүүд санал нэгтгэйгээр гаргана.
- 5.3. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор буюу 50-иас дээш хувийн зөвшөөрсөн саналаар шийдвэрлэнэ.
- 5.4. Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журам болон Монголбанкны зөвшөөрлийн дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Банкнаас шаардах эрхтэй.

ЗУРГАА. БУСАД

- 6.1. Энэхүү Журмын аливаа зүйл, заалт, агуулга хууль тогтоомжтой зөрчилдвөл хууль тогтоомжийг баримтална.
- 6.2. ТУЗ нь Журмын хэрэгжилтэд Дотоод аудитын газар, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан хяналт тавина.
- 6.3. Банкны эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор ТУЗ-өөс тогтоосон журмын дагуу өөрийн холбогдох этгээд, нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг Банканд мэдэгдэх ба уг мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр буюу 10 хоногийн дотор Банканд мэдэгдэнэ.
- 6.4. Банк сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээллийг агуулсан жил, хагас жилийн тайланг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, Компанийн засаглалын кодекс, Худалдаа, хөгжлийн банкны мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмын дагуу эрх бүхий зохицуулах байгууллагуудад хүргүүлэх болон олон нийтэд мэдээнэ.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1. Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтан, хувьцаа эзэмшигчийн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй бол Банк хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.
- 7.2. Журмыг зөрчсөн холбогдох ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран Банк Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Банкны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.
- 7.3. Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь Банкны болон харилцагчийн эд хөрөнгөнд хохирол учруулсан бол түүнд сахилгын, эрүүгийн хариуцлага, түүнчлэн Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл ногдуулсан эсэхээс үл хамааран Банк эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэнэ.
- 7.4. Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтан, хувьцаа эзэмшигчийн үйлдэл, эс үйлдэхүй нь Банкны ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан бол уг гэм хорыг тухайн этгээд хариуцан арилгана.
- 7.5. Банкны эрх бүхий албан тушаалтан нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг гаргаж өгөөгүй, түүнчлэн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь Журмын 3.1 дэх хэсэгт заасан мэдээллийг ТУЗ-ийн дэргэдэх Ажлын алба болон Дотоод аудитын газарт хүргүүлээгүйн улмаас Банк, түүний харилцагчид учирсан аливаа хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр хариуцна.
- 7.6. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн Банкны эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85, 90, 93 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 7.7. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас Банканд учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлөхөөс гадна холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.